



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянзүрх Шижир ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/75/НА-СТА-ОНА

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2023 он</p>	<p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Шонхор үнэлгээ аудит ХХК Захирал: Д.Шийрэв Утас: 88880963 Цахим хаяг: shonkhor.mn@gmail.com Аудитын менежер: Д.Уранчимэг Утас:94064222 Цахим хаяг:urnaа.5804@yahoo.com Ахлах аудитор: Ц.Орхонтамир Утас:99005577 Цахим хаяг:audit.rusbd@gmail.com Аудиторын туслах: Б.Цэрэнлхам Утас:80110088 Цахим хаяг: amuaudit@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024. 03. 15 № 520

танай _____-ны № _____-т

БАЯНЗҮРХ ШИЖИР
ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Ж.ЭНХЗУЛ ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянзүрх Шижир ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Баянзүрх Шижир ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Баянзүрх Шижир ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20.2.9 гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

Орон нутгийн өмчит хуулийн этгээд, түүний албан тушаалтны эрх хэмжээ, төрийн өмчийн талаарх бодлогыг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны зарчим, журмыг тодорхойлох бодлого төлөвлөгөө боловсруулаагүй, санхүү нягтлан бодох бүртгэл, орлого тодорхойлох, хянах үндсэн тулгуур болох амралтын газрын үйлчилгээний үнэ тарифыг тогтоож албажуулаагүй.

Анхны хөрөнгө оруулалт 1,045.1 сая төгрөг нь хөрөнгө эзэмшлийн шинэ чанарыг агуулаагүй, хувь нийлүүлсэн хөрөнгө дансанд бүртгэлгүй, харин өр төлбөр эсвэл тодорхой тайлант үед орлого хүлээн зөвшөөрч татварт тайлагнагдах урьдчилж орсон орлого дансанд бүртгэлтэй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай зохистой нотолгоо олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Баянзүрх Шижир ОНӨААТҮГ-ын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

		2023 оны 01-р сарын 01	2023 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	600,281.96	411,504.93
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага	279,840.41	279,840.41
1.1.6	Бараа материал	35,935,696.11	16,938,267.68
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	36,815,818.48	17,629,613.02
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,179,167,029.73	1,069,119,176.93
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,179,167,029.73	1,069,119,176.93
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,215,982,848.21	1,086,748,789.95
2.1.1.1	Дансны өглөг	2,330,000.00	6,113,776.59
2.1.1.2	Цалингийн өглөг	15,332,712.82	5,437,451.82
2.1.1.3	Татварын өр	16,170,056.18	17,866,672.96
2.1.1.4	НДШ - ийн өглөг	6,892,800.82	3,713,738.82
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	1,047,128,180.20	1,045,128,180.20
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,087,853,750.03	1,078,259,820.39
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,087,853,750.03	1,078,259,820.39
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	91,461,287.78	91,461,287.78
2.3.9	Хуримтлагдсан ашиг	36,667,810.40	(82,972,318.22)
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	128,129,098.18	8,488,969.56
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн	1,215,982,848.21	1,086,748,789.95

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 01-р сарын 01	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	132,015,545.45	110,197,454.55
3	Нийт ашиг (алдагдал)	132,015,545.45	110,197,454.55
8	Бусад орлого	39,160,296.68	
9	Борлуулалт, маркетингийн зардал	199,970,724.99	227,882,285.50
10	Ерөнхий ба удирдлагын зардал	896,761.55	1,955,297.66
11	Санхүүгийн зардал	267,400.00	
12	Бусад зардал	58,000.00	
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(30,017,044.41)	(119,640,128.62)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(30,017,044.41)	(119,640,128.62)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(30,017,044.41)	(119,640,128.62)
24	Орлогын нийт дүн	30,017,044.41)	(119,640,128.62)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2022 оны 1-р сарын 1- ний үлдэгдэл	0.00	0.00	0.00
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	85,698,136.35	85,698,136.35
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	(19,013,281.54)	(19,013,281.54)
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдэл	91,461,287.78	0.00	91,461,287.78
2023 оны 01-р сарын 01- ний үлдэгдэл	91,461,287.78	66,684,854.81	158,146,142.59
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	91,461,287.78	36,667,810.40	128,129,098.18
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	(119,640,128.62)	(119,640,128.62)
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	0.00	0.00
2023 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	91,461,287.78	(82,972,318.22)	8,488,969.56

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 01-р сарын 01	2023 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	149,545,350.00	112,077,200.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	149,545,350.00	112,077,200.00
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	144,424,100.00	112,077,200.00
	Бусад мөнгөн орлого	5,121,250.00	
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	148,945,350.00	112,653,451.69
	Ажиллагчдад төлсөн	75,204,097.22	45,393,147.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	10,668,358.78	12,400,000.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	37,696,509.04	33,665,198.05
	Ашиглалтын зардалд төлсөн	10,493,454.00	4,481,579.31
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,964,329.64	4,792,462.00
	Татварын байгууллагад төлсөн	4,722,173.32	2,021,867.07
	Бусад мөнгөн зарлага	5,196,428.00	9,899,198.26
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	600,000.00	(576,251.69)
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,930,000.00	4,030,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,940,000.00	4,030,000.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	990,000.00	
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,930,000.00)	(4,030,000.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	8,530,000.00	6,817,474.66
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгөн	6,200,000.00	2,400,000.00
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,330,000.00	4,417,474.66
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	418,418.46	(188,777.03)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	181,863.50	600,281.96
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	600,281.96	411,504.93

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 1,045.1 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 3 зөвлөмж өглөө.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой

Илрүүлэлт: Амралтын газрын байрлах Нийслэлийн Засаг даргын захирамжаар олгогдсон БЗД-ийн шар хоолойн аманд байршилтай газар Ачлал эрдэнэ ХХК болон иргэн Б.Гансүх нарын нэр дээр эзэмших эрхийн гэрчилгээтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Амралтын газрын эзэмшигчийн асуудлыг холбогдох дээд байгууллагад хүсэлт гарган шийдвэрлүүлэх, газрыг бүртгэлд тусгах.

2. Бүртгэл тайлагналтай холбоотой

Илрүүлэлт: Санхүүгийн тайлангийн хувь нийлүүлсэн хөрөнгө данс үлдэгдэлгүй, харин урьдчилж орсон орлого дансанд 1,045.1 сая төгрөг тусгагдсан анхны хөрөнгө оруулалт үндсэн хөрөнгийг бүртгэсэн байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл "Нягтлан бодох бүртгэлийн зарчим"-ийн 5.1.4 "Үнэн зөв байх" заалттай нийцэхгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дансны агуулгад тохируулж бүртгэх

3. Үйл ажиллагаатай холбоотой

Илрүүлэлт: 2023 онд байгууллагын үйл ажиллагааны зарчим, журмыг тодорхойлох бодлого төлөвлөгөө боловсруулаагүй, санхүү нягтлан бодох бүртгэл, орлого тодорхойлох, хянах үндсэн тулгуур болох амралтын газрын үйлчилгээний үнэ тарифыг тогтоож албажуулаагүй байна. Энэ нь Баянзүрх шижир ОНӨААТҮГ-ын даргын БЗД-ийн Засаг Даргатай байгуулсан хөдөлмөрийн онцгой нөхцөлтэй гэрээний 2.6 “Үйлдвэрийн газрын жилийн эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшин, удирдлага, зохион байгуулалтын бүтэц, орон, тоо, цалингийн санг хянаж дүүргийн Засаг дарга батална”, 3.12 “Үйлдвэрийн газрын эдийн засаг, бизнесийн үйл ажиллагааны явц, үр дүнгийн талаарх тайланг хагас бүтэн жилээр гаргаж дүүргийн Засаг даргад хүргүүлнэ” заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах, ажил, үйлчилгээтэй холбоотой үнийн тарифыг боловсруулан баталж үйл ажиллагаандаа ашиглах

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Амралтын газрын байрлах Нийслэлийн Засаг даргын захирамжаар олгогдсон БЗД-ийн шар хоолойн аманд байршилтай газар Ачлал эрдэнэ ХХК болон иргэн Б.Гансүх нарын нэр дээр эзэмших эрхийн гэрчилгээтэй байна	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Санхүүгийн тайлангийн хувь нийлүүлсэн хөрөнгө данс үлдэгдэлгүй, харин урьдчилж орсон орлого дансанд 1,045,128.2 мянган төгрөг тусгагдсан анхны хөрөнгө оруулалт үндсэн хөрөнгийг бүртгэсэн байна	1	1,045.1	-	-	-	-	1	1,045.1	-	-	-	-
2023 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан батлуулаагүй, амралтын газрын үнэ тарифыг албан ёсоор тогтоогоогүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Дүн	3	1,045.1	-	-	-	-	3	1,045.1	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Автомашин улсын дугаарыг цэнхэр дэвсгэрээр солиогүй	1	-	-	-	-	-	1	-
Дүн	1	-	-	-	-	-	1	-